БАТЛАВ:
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ТӨМӨРХҮҮ

ХОТ, СУУРИН ГАЗРЫН ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр

Дугаар 2025/13

Улаанбаатар хот

№	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Захиалагч байгууллага	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
2.	Хариуцах нэгж, хэлтэс	Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын Хот дахин төлөвлөлтийн хэлтэс
3.	Байршил	Улаанбаатар хот, Барилгачдын талбай, Засгийн газрын XII байр, Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо
4.	Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны зорилт 2.5.3-т "Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ." гэж, 3.2.3-т "Хот, суурин газрын хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах хөтөлбөр, төслийг үе шаттай хэрэгжүүлж, иргэдийг орлогод нийцсэн аюулгүй, ая тухтай орон байртай болоход дэмжлэг үзүүлнэ." гэж, 3.2.5-д "Хот, суурин газрын гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөх, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ." гэж, 3.6.1-д "Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно." гэж тус тус заасан. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн "1.1.Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт гэсэн хэсгийн 1.1.1-д "Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл" гэж, 4.2.4.3-т "Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана." гэж тус тус тусгасан.
5.	Ажлын даалгаврын нэр	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төслүүд, дагалдан гарах хууль тогтоомжийн төслүүд, хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдон гарах тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо хийх болон хуулийн төслийг дагалдан батлагдах журам, аргачлалын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээ
6.	Ажлын зорилго, зорилт	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлалын төслүүд, дагалдан гарах хууль тогтоомжийн төслүүд, хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдон гарах тандан судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо

		хийх болон хуулийн төслийг дагалдан батлагдах журам, аргачлалын төслийг одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа холбогдох бусад хууль тогтоомжуудтай уялдуулан боловсруулахад оршино.
7.	Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажлын иж бүрдэл	Зөвлөх үйлчилгээний хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд: 1.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ын дагуу Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалж зөвлөмж гаргана. Үүнд: -Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцэж байгаа эсэхийг судалж, зөвлөмж гаргах; -Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах; -Хот, суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судалж, дүгнэлт хийх; -Хуулийн төслийн хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцох; -Хуулиар зохицуулах, шийдвэрлэх хамгийн үр дүнтэй хувилбаруудыг тодорхойлж, харьцуулан дүгнэх; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтын талаар олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх. (4-өөс доошгүй улс, орны туршлагыг судалсан байна) 2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 14, 15 дугаар зүйлд заасны дагуу Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөлд дараах асуудлыг тусган боловсруулна. Үүнд: -Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох; -Хуулийн төслийг боловсруулж, батлуулах шаардлага, хэрэгцээ үүдэн гарч байгаа хууль зүйн болон шинжлэх ухаан, техник, нийгэм, эдийн засгийн үндэслэлийг тодорхойлох; -Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа (хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд заасан төрөл бүрээр)-г зохицуулсан эрх зүйн орчин, практикт уг асуудалтай холбоотой ямар зөрчил, дутагдал, шийдвэрлэх нийтлэг асуудал байгаа, эсхүл үүнтэй холбоотой хичнээн тохиолдол гарсан талаар тоо, баримт болон жишээ; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг хуулиар зохицуулахгүй бол ямар үр дагавар гарч болох, хуулийг дагалдуулан баталсан холбогдох журмуудаар зохицуулж байгаа асуудал бусад хуульд заасан иргэний хууль ёсны эрхийг зөрчих, хязгаарлах гэх мэт асуудлыг тодорхойлох;

		-Хуулийн төслийг боловсруулж, батлуулах гаргах хэрэгцээ, шаардлага байгааг нотолсон эрдэмтэн, судлаачдын хийсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон холбогдох байгууллагуудаас гаргасан санал, дүгнэлтийг үзэл баримтлалд тусгаж болно; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичиг; -Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг оновчтой тодорхойлох; -Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагаврыг тодорхойлж, гарах үр дүн, тэдгээр (нийгэмд гарч болох сөрөг үр дагавар)-ийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал; -Хуулийн төсөл батлагдсанаар санхүүгийн хувьд нэмэлт эх үүсвэр шаардагдах эсэх, ажлын байр нэмэгдэх, шинээр байгууллага байгуулах, эсхүл байгууллага дотор шинээр нэгж, алба бий болох эсэх, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж нэмэх зэрэг эдийн засгийн хувьд нэмэлт зардал гарах эсэх, тухайн асуудлыг хуулиар зохицуулах хэрэгцээ нь нийгэмд хүлээлт үүсгэсэн эсэх, нийгмийн тодорхой харилцааг үүсгэх, өөрчлөх, илүү нарийвчлан зохицуулах эсэх зэргийг тусгах. 3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасны дагуу Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. Үүнд: -Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг удирдлага болгон Хот , суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна. 4.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3-р хавсралтаар баталсан Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, зардлын тооцоог гаргана. Үүнд: -Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлтийг оновчтой байдлаар тодорхойлно. (Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын 2.2-т заасны дагуу); -Хуулийн шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой зохицуулалтыг сонгон тогтоож, үр нөлөөг нь үнэлнэ; -Хуулийн төслийн үр нөлөөний үр дүнг үнэлж, зөвлөмж өгнө. 5.Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүдийг боловсруулна. 6.Хуулийн төслийг дагалдан батлагдах журам, аргачлалын төслийг боловсруулна. Үүнд: -Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг дагалдан батлагдсан 8 журмын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж, хуулийн төсөлд нийцүүлэн шинэчлэн боловсруулах. 7.Хуулийн төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэнэ.

		8.Хуулийн төслийг иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлэх, Засгийн газарт өргөн мэдүүлэхэд Зөвлөх хамтран ажиллана. 9.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ыг удирдлага болгон хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийнэ.
8.	Арга зүй	-Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; -Хууль тогтоомжийн тухай хууль; -Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор хавсралтаар баталсан аргачлал; -Засгийн газрын 2021 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам"; -Бодлогын судалгааны нийтлэг бусад арга зүйг тус тус ашиглана.
9.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлийн 90 хоног
10.	Зөвлөх багийн бүрэлдэхүүн	10.Хуулийн этгээд: -Эрх зүйч, архитектор, хот төлөвлөлт, газар зохион байгуулалт болон нийгмийн ухаан, эдийн засгийн чиглэлийн мэргэжилтнээс бүрдсэн баг байх; -Багийн гишүүдийн гуравны хоёр нь хуульч, гуравны нэг нь архитектор хот төлөвлөгч, газар зохион байгуулагч байвал давуу тал болно.
11.	Зөвлөх багт тавигдах шаардлага болон ажлын туршлага	11.Ажлын хэсгийн ахлагч: -Хууль зүйн ухааны магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх; Ажлын хэсгийн гишүүд: -Архитектур, хот төлөвлөлт, газар зохион байгуулагч, хууль, эрх зүйн чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх; -Бодлогын баримт бичиг, хот суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбоотой 3-аас доошгүй удаа төрийн болон төрийн бус байгууллагын хөндлөнгийн судалгаа, шинжилгээ хийсэн, салбарын хуулийн төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан ажлын туршлагатай байх; -Хуулийн төсөл (боловсруулсан, батлуулсан), судалгааны ном, тайлан, эмхэтгэл, зөвлөмж, илтгэл, өгүүлэл боловсруулахад оролцсон туршлагатай байх; -Хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, богино хугацаанд ачаалалтай ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх.
12.	Судалгааны ажлын тайлангийн үе шат	12.<u>Эхлэлийн тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 10 хоногийн дотор эхлэлийн тайланг Захилагчид хүлээлгэн өгнө. Үүнд: -Судалгааны тайлангийн ерөнхий загвар, мэдээллийг нэгтгэх, цуглуулах, боловсруулах аргачлалыг тодорхойлж, ажлын нарийвчилсан төлөвлөгөө;

		-Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалгааны тайлан; -Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, зөвлөмж; -Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл. <u>Дунд шатны тайлан:</u> Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 30 хоногийн дотор дунд шатны тайланг Захилагчид хүлээлгэн өгнө. Үүнд: -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хувилбар; -Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооны тайлан; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд захиалагчаас өгсөн саналыг тусган боловсруулсан төслийн хувилбарын танилцуулга; -Хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүд болон мөн дагалдан батлагдах журам, аргачлалыг төслийн танилцуулга. <u>Сүүлийн шатны тайлан:</u> -Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 90 хоногийн дотор сүүлийн шатны тайланг Захилагчид хүлээлгэн өгнө. Үүнд: -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал батлагдсан байна; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэн, хуулийн этгээд, олон нийтийн саналыг тусган ажлын хэсгээр хэлэлцүүлж, эцэслэн боловсруулсан төслийн хувилбар; -Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн төслийг дагалдан батлагдах журам, аргачлалыг төсөлд ажлын хэсгийн саналыг тусган боловсруулсан төсөл. -Хуулийн төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулга.
13.	Ажлын зохион байгуулалт болон үр дүнг тайлагнах, хүлээлгэн өгөх	13.Зөвлөх баг ажлын зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр Ажлын даалгаварт өөрчлөлт оруулж болно. Зөвлөх баг Төрийн нарийн бичгийн даргатай гэрээ байгуулж ажиллана. Зөвлөх баг дүн шинжилгээ хийх үе шат, арга хэмжээг сонгох, тодорхойлох, томьёолохдоо хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн даргатай зөвшилцөж ажиллана. Зөвлөх баг ажлын хэсгийн ахлагч, гишүүдтэй зөвлөх үйлчилгээний ажлын талаар тухай бүр харилцаж, уулзалт, ярилцлага хийх болон шаардлагатай мэдээ, мэдээлэл, тоо, баримт, судалгаа, тайлан, дүгнэлт, санал, зөвлөмжийг авч, хуулийн төсөл, судалгаанд тусгаж хамтран ажиллана.

		Зөвлөх баг захиалагчийн хүсэлтийн дагуу тухай бүр ажлын явцын танилцуулгыг хийнэ. Зөвлөх баг захиалагчид энэ ажлын даалгаврын 12-т заасан ажлыг цахим болон цаасан хэлбэрээр хүлээлгэн өгнө.
14.	Захиалагчийн хяналт	14.Захиалагчийн хяналтыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам гүйцэтгэнэ.
15.	Зөвлөх үйлчилгээний үнэ, санхүүжилт	15.Мөнгөн дүн: 50,000,000 (тавин сая) төгрөг. Барилга байгууламжийн норм нормативын сангаас. Зардлын тооцоо-Хавсралт-1
16.	Төлбөрийн нөхцөл	16.Ажлын хөлсийг төлбөрийн стандарт арга буюу ажлын үр дүнд үндэслэсэн хэлбэрээр, гэрээнд заасны дагуу ажлын даалгаврын гүйцэтгэлээр хэсэгчлэн төлнө. Төлбөрийг монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.
17.	Даалгаварт тусгагдаагүй ажил	17.Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэж болох бөгөөд үүнийг гэрээний тусгай нөхцөлөөр тодорхойлно.
18.	Төрийн нууцыг хадгалах, хамгаалах	18.Төрийн болон албаны нуущын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад журам, зааврын дагуу төрийн нуущыг хадгалах, хамгаалах ажлыг зохион байгуулна.

ХЯНАСАН:

Хот байгуулалт бодлого, зохицуулалтын газрын дарга — Ц.БАЯРБАТ

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — Б.СҮХБАТ

Хуулийн хэлтсийн ахлах шинжээч — Ц.БАТЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын Хот дахин төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч — А.ЭНХНАРАН

Хот дахин төлөвлөлтийн хэлтсийн шинжээч — Б.ГОЁСАЙХАН

ХОТ, СУУРИН ГАЗРЫГ ДАХИН ХӨГЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТӨСЛҮҮДИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХОЛБОГДОХ СУДАЛГАА, ҮНЭЛГЭЭ ХИЙХ БОЛОН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН БАТЛАГДАХ ЖУРАМ, АРГАЧЛАЛЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Хавсралт 1.

Д/д	Гүйцэтгэх ажил	Ажлын хөлс (мян.төг)	Ажлын үр дүн
1	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх	1,000.0	Өмнө хийсэн үнэлгээний тоо баримтыг шинэчлээд ашиглах боломжтой.
2	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах	3,000.0	Тандан судалгааны тайлан гарсан байна.
3	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж батлуулах	8,000.0	Үзэл баримтлалын төслийг батлуулсан байна.
4	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах	35,000.0	Хуулийн төсөл болон хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан байна.
5	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, зардлын тооцоог гаргах	2,000.0	Үр нөлөөний тайлан гарсан байна.
6	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлж, санал авах	1,000.0	Хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг хуулийн төсөлд тусгасан байна.
	Хуулийн төслийг дагалдан батлагдах журам, аргачлалыг төслийг боловсруулах		
7	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах	-	Санал авч хуулийн төсөлд тусгасан байна.
8	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх	-	Засгийн газарт өргөн мэдүүлсэн байна.
9	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	-	Хуулийн төслийн бүрдлийг хангасан байна.
	НИЙТ	50,000.0	

ХЯНАСАН:

ХББОСЯ-НЫ ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Ц.БАЯРБАТ

ХББОСЯ-НЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.СҮХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХББОСЯ-НЫ ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ЭНХНАРАН

ХББОСЯ-НЫ ХОТ БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХОТ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ Б.ГОЁСАЙХАН